

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.САРАНЧУЛУУН

**ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

2026 оны 07 дугаар сарын 01

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улс хуулийн Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1-т “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.”, мөн зүйлийн 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасны дагуу аж ахуйн нэгж, хуулийн этгээдийг дэмжих, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.4.4-т “Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.”, 3.3.15-д “Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.”, 4.5.10-т “Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлж, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг баталсан. Тус үндсэн чиглэлийн 84-т “Хамтын санхүүжилтийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхийг даалгасан боловч холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас өнөөг хүртэл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-т “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай програм хангамжаар дамжуулан гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчийн хооронд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулна.” гэж заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж заасныг тус тус үндэслэн Хамтын санхүүжилтийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна.

1.1. Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсад бизнес эрхэлж буй гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид аливаа шинэ бүтээгдэхүүн, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг босгоход уламжлалт банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлээс хэт хамааралтай хэвээр байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагаас тавьж буй барьцаа хөрөнгө, зээлийн шалгуур үзүүлэлт, гэрээний уян хатан бус нөхцөл зэргээс шалтгаалан олон жижиг бизнесүүд шаардлагатай санхүүжилтийг авч, хөрөнгө оруулалт босгож чадахгүй байгаагаас зах зээлд тэгш өрсөлдөх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжоо хязгаарлуулж, дампуурах, татан буугдах эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын бизнес регистрийн өгөгдлийн санд 2023 оны жилийн эцсийн байдлаар 101.6 мянган хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагийн 76.6 мянга (75.4%) нь ЖДҮҮЭ аж ахуйн нэгж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлд бий болсон нэмэгдэл өртгийн хэмжээ 2023 онд 3.8 их наяд төгрөг болж, 2022 оноос 1.2 их наяд төгрөг буюу 48.7 хувиар нэмэгдсэн бөгөөд ДНБ-ий 6.2 хувийг ЖДҮҮЭ нэгжүүд үйлдвэрлэжээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эдийн засгийн салбараар авч үзвэл, 2023 онд хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн салбарын нэмэгдэл өртөгт эзлэх хувь 3.7, үйлдвэрлэлийн салбарынх 2.9, үйлчилгээний салбарынх 7.6 хувьтай байна.¹

Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдлын талаарх 2023 оны түүвэр судалгааны² үр дүнгээр хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын орчны индексийн утга -0.36 буюу бизнес эрхлэх таатай орчин хангалттай бүрдээгүй байна гэсэн үнэлгээтэй гарсан. Монгол Улсын татварын дарамт 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 34% хүрсэн байна. Улсын төсвийн орлого 2022 оны 11 сартай харьцуулахад 2023 оны 11 сарын байдлаар 38%-ийн өсөлттэй байна. Үүнээс ААНОАТ 127%, ХХОАТ 39%, Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 30%, бусад татварын орлого 99%-аар өссөн байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо 2022 оны 11 сартай харьцуулахад 2023 оны 11 сарын байдлаар 6.3%-аар өссөн. Улсын татварын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38%-аар нэмэгдсэн нь төрийн үйлчилгээний татвар шимтгэл хураамж бүрдүүлэлт нь бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй зардал гэсэн хариултаар харагдаж байна.

Хуулийн этгээд, ААН-үүдийн хувьд санхүүжилт, хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, авилгыг бууруулах зэрэг үйл ажиллагаанд төр, засгийн зүгээс анхаарал хандуулж, сайжруулах

¹ Үндэсний статистикийн хороо, Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр 2023, 2024, https://downloads.1212.mn/idd_sl8Pel8sb6tmb_iO-S- --58_Yu_71qB3JXk.pdf

² Монголбанкнаас жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн үйл ажиллагаа, бизнесийн нөхцөл байдал болон санхүүжилтийн талаар 2011 оноос хойш ЖДҮ-ийн түүвэр судалгааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ирсэн бөгөөд 2020 оноос эхлэн уг түүвэр судалгааны хамрах хүрээг өргөжүүлж, том аж ахуйн нэгжүүдийг оролцуулж эхэлсэн.

шаардлагатай байгаа талаарх саналыг голчлон гаргажээ.³ Хуулийн этгээд буюу бизнес эрхлэгчдийн 60% нь санхүүжилтээ өөрсдийн эх үүсвэрээр шийддэг бол 36% нь дотоодын банк, санхүүгийн байгууллагаас зээл авч санхүүждэг байна. Банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур, зээлийн нөхцөл (хүү, хугацаа, хэмжээ) хатуу, бичиг баримт бүрдүүлэлт их байгаа нь хамгийн их хүндрэл учруулдаг гэж ихэнх ЖДҮ эрхлэгчид үзсэн бөгөөд энэ нь 2021 оны өөрчлөгдөөгүйг илтгэнэ.⁴

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ААНБ-ын тоо 2024 оны IV улиралд 52.7 мянга, ажиллагсдын тоо 787.4 мянга бөгөөд 2024 онд нийт тайлан ирүүлбэл зохих хуулийн этгээдийн 82.0 хувь буюу 176,637 хуулийн этгээд тайлан ирүүлсэн гэж Сангийн яамны танилцуулгад дурдсан байна. Үүнийг 2024 оны IV улирлын 52.7 мянган шимтгэл төлөгч ААНБ-тай харьцуулахад, тайлан ирүүлсэн хуулийн этгээдийн зөвхөн ойролцоогоор 29.8 хувь нь нийгмийн даатгалын идэвхтэй ажил олгогч хэлбэрээр харагдаж байна. Энэ нь бүртгэлтэй болон тайлантай бизнесийн хөрөнгө, борлуулалт, ажиллах хүчний чадавх сул олон ААН байгааг харуулж байна.

Дээрх судалгааны дүгнэлтийг нэгтгэн үзвэл бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, санхүүжилт, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, авлигыг бууруулах, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр олшруулах, хүний нөөцийг дэмжиж, хуулийн этгээдийн насжилтийг уртасгах зэрэг бодлого, үйл ажиллагааны арга хэмжээнүүдийг нэн даруй авах шаардлагатай гэж үзжээ.

Хамтын санхүүжилтийн эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас гэмт хэргийн хохирогч болох нөхцөл байдал нэмэгдэж, гэмт хэргийн үйлдлийн арга нь улам бүр нарийсч урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцлээр халхавчилж, хандив, тусламж авах зэргээр зохиомол байдлыг зориудаар бүрдүүлэх, олон шатлалт сүлжээний аргаар үйлдэх болсон байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 30-35 хувийг залилах гэмт хэрэг эзэлдэг ба цаашид залилах гэмт хэрэг нэмэгдэх төлөвтэй байна.⁵

Иймд зохицуулалтгүй хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагаа нэмэгдэж байгаа нь санхүүгийн зах зээлийн ил тод, найдвартай байдлыг хангах, хөрөнгө оруулагч болон санхүүжилт хүсэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Цаашид хамтын санхүүжилт буюу онлайн платформоор дамжуулан шинэ санаачилга, бүтээгдэхүүн, үйлчилгээ, төсөл, зээлийг санхүүжүүлэх зорилгоор олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх орчин үеийн санхүүжилтийн арга хэрэгслээр шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага тулгамдсан.

³ Монголбанк, Судалгаа, статистикийн газар түүвэр судалгаа, шинжилгээний хэлтэс, Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, 2023 оны түүвэр судалгааны үр дүн, file:///C:/Users/User/Downloads/%D0%91%D0%B8%D0%B7%D0%BD%D0%B5%D1%81%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D2%AF%D2%AF%D0%B2%D1%8D%D1%80%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0_2023.pdf

⁴ Монголбанк, Судалгаа, статистикийн газар түүвэр судалгаа, шинжилгээний хэлтэс, Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, 2023 оны түүвэр судалгааны үр дүн, file:///C:/Users/User/Downloads/%D0%91%D0%B8%D0%B7%D0%BD%D0%B5%D1%81%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D2%AF%D2%AF%D0%B2%D1%8D%D1%80%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0_2023.pdf

⁵ Залилах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, ДХИС, 2023 он он, <https://sudalгаа.gov.mn/zalilakh-gemt-khergiyn-shaltgaan-nkhtsl-urdchilan-sergiylekh-arga-zam-lvs>

Хамтын санхүүжилтийн тогтолцоо нь бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон нийтэд шууд танилцуулан урьдчилсан санхүүжилт босгох боломжийг бүрдүүлдэг бөгөөд үндсэн зуучлагч нь онлайн платформ бөгөөд уг платформоор дамжуулан санхүүжилт хүсэгч нь шаардлагатай хөрөнгийн хэмжээ, зориулалт, хөрөнгө оруулагчид олгох өгөөжийн нөхцөлийг нийтэд мэдээлдэг.

Хөрөнгө оруулагчид тухайн мэдээлэлд үндэслэн санхүүжүүлэх эсэх шийдвэрийг гаргадаг. Олон улсын практикт “all-or-nothing” буюу зорилтот дүн бүрдээгүй тохиолдолд хөрөнгийг буцаан олгох зарчим өргөн хэрэглэгдэж байна. Тухайлбал, Урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь олон нийтийн хамтын санхүүжилт, зээл болон хувьцаанд суурилсан хамтын санхүүжилтийг хамтад нь санхүүгийн өгөөж хүртэх хамтын санхүүжилт гэж нэрлэдэг. Эдгээр төрлийн гол ялгаа нь урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилт нь ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт эсвэл санхүүгийн өгөөж хуваарилдаггүйд оршино.

Санхүүгийн салбарын уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд зээлийн нөхцөл, шаардлагыг чангатгаж, эрсдэлийг бууруулах бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлт буурах хандлага ажиглагдаж байна. Үүний улмаас бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд чухал үүрэг бүхий өрхийн болон бичил үйлдвэрлэлийн салбарыг санхүүжүүлэх шинэ, хүртээмжтэй санхүүгийн арга хэрэгслийг хөгжүүлэх шаардлага бий болсон. Энэхүү хэрэгцээ, шаардлагын хүрээнд хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад цахим платформд суурилсан хамтын санхүүжилтийн төрөл, хэлбэрүүд эрчимтэй хөгжиж, бизнес эрхлэгчдийг дэмжих үр ашигтай санхүүгийн механизмын нэг болж төлөвшиж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтийн үйлчилгээ эрчимтэй хөгжиж гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих үр ашигтай хэрэгсэл болж байна. Судалгаагаар 2024 оны байдлаар дэлхий дахинд хамтын санхүүжилтийн платформоор дамжуулан татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн хэмжээ 166.95 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд уг хэмжээ 2032 онд 2,801.29 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгааг судлаачид онцолж байна.

Иймд олон улсын жишигт нийцүүлэн, хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тодорхойлох, төрөөс хяналт, зохицуулалт хийх замаар санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, мөн хамтын санхүүжилтийн хүрээнд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгох практик шаардлага үүсээд байна. Хамтын санхүүжилтийн эрх зүйн орчин бүрдүүлснээр дараах давуу тал үүснэ. Үүнд:

- Зардал багатай санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бий болгох;
- Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих;
- Хандив, урамшууллын тогтолцооны ил тод байдлыг нэмэгдүүлж, залилах гэмт хэргийн эрсдэлийг бууруулах;
- Хөрөнгө оруулалтын шинэ боломжийг нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж заасныг үндэслэн анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байх бөгөөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

- Хуулийн төслийн зорилт нь хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйлчилгээтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

- Хуулийн төсөлд хувьцаа, зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн хэлбэрийг тусгаж, уг харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг зохицуулна.

- Хуулийн зорилт, хамтын санхүүжилтийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёо зэргийг тодорхойлно.

- Хувьцаанд суурилсан, зээлд суурилсан, урамшуулалд суурилсан, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ, тэдгээрт тавих шаардлагыг тодорхойлон тусгана.

- Хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч, түүнд тавигдах хүний нөөц, програм хангамж, эрх бүхий албан тушаалтнуудын шаардлага, хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, тайлан, мэдээлэл ирүүлэх хугацаа, програм хангамжид ил тод нээлттэй байршуулах мэдээлэл, хувьцаа болон зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгчид олгох зөвшөөрөл түүнд ирүүлэх баримт бичиг, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг зохицуулалтыг тусгана.

- Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн харилцагчид үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байдлаар өгөх мэдээлэл, гомдол хүлээн авах болон түүнийг шийдвэрлэх хугацаа зэргийг тусгана.

- Хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэгч нь баримт мэдээллийг хэрхэн хадгалах, үйлчилгээтэй холбоотой аливаа зар сурталчилгааг харилцагчид төөрөгдөлгүй, тодорхой, ойлгомжтой байдлаар хүргэх, мэдэгдлийн хүрээнд эрхлэх урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээнд хяналт тавих этгээд болон хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хамтын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж баталснаар дараах үр дүнд хүрнэ гэж тооцож байна. Үүнд:

1.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлж, эдийн засгийн бодит өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих нөхцөл бүрдэнэ.

2.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрээ хөрөнгийн зах зээл дээрээс бага зардлаар, богино хугацаанд татан төвлөрүүлэх боломжтой болох ач холбогдолтой.

3.Урамшуулал болон хандивт суурилсан хамтын санхүүжилтийг зохицуулснаар залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

4.Онлайн платформын бүтэц, үйл ажиллагааны зардал харьцангуй бага тул санхүүжилт хүссэн этгээдийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах эерэг нөлөөтэй.

5.Цахим орчин дахь зохицуулалтгүй хөрөнгө татах үйл ажиллагааг хамтын санхүүжилтийн эрх зүйн орчинд оруулснаар залилангийн шинж чанартай хэт өндөр өгөөж амласан хөрөнгө татах үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх бодит механизм бүрдэнэ.

6.Хамтын санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн санхүүжилт татан төвлөрүүлэх суваг нэмэгдэж гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн бизнесийг дэмжих, худалдааны эргэлтийг сайжруулах, эдийн засгийн идэвхжлийг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.